



# **АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ**

**Энэ хуулийг 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн  
дагаж мөрдөнө.**



## **Авлига**

**Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах цйлдэл, эс цйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг**

**/3.1.1 дүгээр зүйл. Авлига /**



## **АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИЙН ХОРИГЛОХ ЗҮЙЛ**



**Албан цүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах; албан цүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;**

**7 дугаар зүйл.Хориглох зүйл**



## АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИЙН ХОРИГЛОХ ЗҮЙЛ




Албан цүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;  
Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;  
Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;  
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

7 дугаар зүйл.Хориглох зүйл



## АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИАС



Иргэн, хуулийн этгээд  
авлигын асуудлаар Авлигатай  
тэмцэх газарт өргөдөл, гомдол  
гаргаж, мэдээлэл өгч болно

9 дүгээр зүйл.Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх



## **АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИАС**



**Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн.**

**15 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газар**



## АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИЙН ХОРИГЛОХ ЗҮЙЛ




Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллана

27 дугаар зүйл. Олон нийтийн зөвлөл



## АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИАС



Авлигатай тэмцэх газрын байранд улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно

28 дугаар зүйл.Улс төрийн баталгаа





## АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИАС



Мэдээлэх цүргээ удаа дараа биелцүүлээгүй, эсхүл энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох

33 дугаар зүйл.Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага



## **АВЛИГЫН ЭСРЭГ ТУХАЙ ХУУЛИАС**



**Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрцүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан мэдээлэх үүргээ биелцүлээгүй бол цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах.**

**33 дугаар зүйл. Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**